



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 24 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “15.12” гэсний дараа “, 15.33” гэж, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг,” гэсний дараа “15.33 дугаар зүйл,” гэж, мөн зүйлийн 14 дэх хэсгийн “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “15.33 дугаар зүйл,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Зөрчлийн тухай хуулийн 15.33 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шүүгчийн торгох шийтгэлийн биелэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусад зөрчил үйлдсэн хүнд оногдуулсан шүүгчийн торгох шийтгэлийн биелэлтийг тухайн зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулсан эрх бүхий байгууллага тус тус хариуцна.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР